

Байгууллагын нэр: Нийслэлийн Спортын хороо

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫНЗАХИРАГЧИЙН 2016-2020 ОНЫ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ**

**Үндсэн хэрэгжүүлэх 10 арга хэмжээ**

2020 оны жилийн эцсийн байдлаар

Улаанбаатар хот

Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд <b>үндсэн</b> хэрэгжүүлэгчээр туссан нийт 10 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж 100% байна.	
Үндсэн хэрэгжүүлэхээр тусгагдсан нийт- 8 арга хэмжээ	
Үр дүнтэй /100%/	7
Тодорхой үр дүнд хүрсэн /70%/	-
Эрчимжүүлэх шаардлагатай /40%/	-
Үр дүнгүй / 0-30% /	-
Үнэлэх боломжгүй	1
<b>Биелэлтийн дундаж хувь</b>	<b>100%</b>

**Хамтран хэрэгжүүлэх арга хэмжээ**

Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд <b>хамтран</b> хэрэгжүүлэгчээр туссан нийт 2 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж 70% байна.	
Хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан Нийт- 2 арга хэмжээ	
Үр дүнтэй /100%/	-
Тодорхой үр дүнд хүрсэн /70%/	1
Эрчимжүүлэх шаардлагатай /40%/	-
Үр дүнгүй / 0-30% /	-
Үнэлэх боломжгүй	1
<b>Биелэлтийн дундаж хувь</b>	<b>70%</b>

Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд арга хэмжээний биелэлт 100%-тай хэрэгжсэн байна.

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫНЗАХИРАГЧИЙН 2016-2020 ОНЫ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ**

**ДӨРӨВ. НИЙГМИЙН ХӨГЖИЛ /НИЙСЛЭЛИЙН СПОРТЫН ХОРОО/**

2020 оны 12 дугаар сарын 25

Улаанбаатар хот

№	Заалт	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хариуцах байгууллага	Хариуцах удирдлага	Гүйцэтгэлийн хувь	Үнэлгээний хувь
<b>4.4. Нийтийн биеийн тамир, спорт</b>						
1	4.4.1	<b>Олон улсын жишигт нийцсэн шинэ цэнгэлдэх хүрээлэн барина.</b>	<b>НСХ</b>	<b>Ш.Анхмаа</b>	<b>ҮБ</b>	<b>ҮБ</b>
		<p><b>2017 онд:</b> Олон улсын жишигт нийцсэн шинэ цэнгэлдэх хүрээлэн барих байршил, газрыг шийдвэрлүүлэх саналыг Нийслэлийн Газрын алба, Нийслэлийн Хот байгуулалт, Ерөнхий төлөвлөгөөний газарт тавьж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бодлого төлөвлөлтийн хэлтсээс зөвлөгөө авч ажилласан. 2017 оны улсын болон орон нутгийн төсөвт хөрөнгө тусгагдаагүй учир ажил эхлээгүй.</p> <p><b>2018 онд:</b> Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 20/20 дугаар тогтоолоор “Нийслэлийн өмчийн концесс”-ын зүйлийн жагсаалтад олон улсын жишигт нийцсэн шинэ цэнгэлдэх хүрээлэн барих ажил тусгагдсан. Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газраас Улаанбаатар хотод 35000 хүний суудалтай цэнгэлдэх хүрээлэнгийн концепц боловсруулах уралдааныг архитектор, мэргэжлийн оюутнуудын дунд сарын хугацаатай зарласан боловч ирүүлсэн материалууд хангалтгүй байсан тул концепц шалгараагүй.</p> <p><b>2019 онд:</b> Олон улсын жишигт нийцсэн үндэсний хэв шинж бүхий 30-40 мянган хүний багтаамжтай “Үндэсний төв цэнгэлдэх хүрээлэнг Нийслэлийн Хан-Уул дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт Нисэх, Яармагийн аюулгүйн тойргийн зүүн урд хэсэгт барьж байгуулахаар шийдвэрлэсэн. “Үндэсний төв цэнгэлдэх хүрээлэн” байгуулах төслийн концепц, загвар зураг төсөл боловсруулах уралдааныг зарлан, сонгон шалгаруулалтыг хийж “Хаус дизайн” ХХК-ны боловсруулсан “Хийморь цогцолбор” бүтээл шалгарсан. “Үндэсний төв цэнгэлдэх хүрээлэн”-гийн төслийн техник, эдийн засгийн үндэслэл, эх загвар зураг (эскиз)-ийг боловсруулах ажлыг Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, хот байгуулалт хөгжлийн газар хамтран хийж байна.</p> <p><b>2020 онд:</b> “Үндэсний төв цэнгэлдэх хүрээлэн”-гийн төслийн техник, эдийн засгийн үндэслэл, эх загвар зураг (эскиз)-ийг боловсруулах ажлыг Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, хот байгуулалт хөгжлийн газар хамтран гүйцэтгэж байна. “Үндэсний төв цэнгэлдэх хүрээлэн” байгуулах төслийн концепц, загвар зураг төсөл боловсруулах уралдааныг зарлан, сонгон шалгаруулалтыг хийж “Хаус дизайн” ХХК-ны боловсруулсан “Хийморь цогцолбор” бүтээл шалгарсан. Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1046 дугаар “Газар эзэмших эрх олгох тухай” захирамжаар Хан-Уул дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт байршуулан 30.0 га газарт “Үндэсний төв цэнгэлдэх хүрээлэн” байгуулах зориулалтаар 15 жилийн хугацаатай газар эзэмших эрхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт олгосон байна.</p>				

Үр дүн:	Үндэсний хэв шинж бүхий 30-40 мянган хүний багтаамжтай “Үндэсний цэнгэлдэх хүрээлэн” барих байршил, газрын асуудлыг шийдвэрлэж зураг төслийг шалгаруулсан.					
2	4.4.2	<p><b>Нийслэлийн иргэдэд нийтийн биеийн тамир, спортын үйлчилгээг хүргэх тогтолцоог боловсронгуй болгож, “Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх хөтөлбөр” хэрэгжүүлнэ.</b></p>	НСХ	Ш.Анхмаа	93%	100%
		<p><b>2017 онд:</b> “Нийслэлд Биеийн тамир, спортыг 2017-2020 онд хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийг боловсруулахдаа дүүргийн Биеийн тамир, спортын хороодоос албан бичгээр санал авч, шуурхай зөвлөгөөнд танилцуулж ажилласан. Төслийг 2017 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр биеийн тамир, спортын салбарын багш, эрдэмтэн судлаачид, спортын холбоодын төлөөлөл, дүүргийн Биеийн тамир, спортын хорооны дарга, мэргэжилтэн зэрэг 23 байгууллагын 33 хүнийг хамруулан танилцуулах уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан. Дэд хөтөлбөрийн төслийг 2017 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр Нийслэлийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулж зөвлөлийн хурлаар дэмжигдсэн. Засаг даргын зөвлөлийн гишүүдийн дэд хөтөлбөрийн төсөлд өгсөн саналыг тусган Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд 2017 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 01/3400 албан тоотоор өргөн барьсан.</p> <p><b>2018 онд:</b> Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 88 дугаар тогтоолоор 4 зорилт, тэдгээрийн хүрээнд хэрэгжүүлэх нийт 19 үйл ажиллагаа бүхий “Нийслэлд биеийн тамир, спортыг 2017-2020 онд хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийг баталсан. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/1200 дугаар захирамжаар батлуулсан. Тус дэд хөтөлбөрийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажил 80 хувьтай хэрэгжсэн.</p> <p>Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж Улаанбаатар марафон, Нийслэлийн иргэдийн спортын VII наадам, “Мөнгөн Улаанбаатар” өвлийн наадам, Хотын захирагчийн нэрэмжит “Улаанбаатар лиг” ЕБС-ийн сурагчдын волейбол, сагсан бөмбөгийн тэмцээн, хөлбөмбөгийн “UB cup”, “Дуулиан 2020” зэрэг олон нийтийг хамруулан спортын томоохон тэмцээн уралдааныг нас насны онцлогт тохируулан зохион байгуулсан. Нийслэлийн иргэдэд биеийн тамир, спортын үйлчилгээг хүртээмжтэй хүргэх үйл ажиллагааны хүрээнд хүний нөөц боловсон хүчний чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор нийслэл болон дүүргүүдийн албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх 62 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын хороодын орон тоог 5 нэмэгдүүлж цалингийн асуудлыг шийдвэрлүүлсэн.</p> <p>Улсын төсвөөр нийслэлд биеийн тамир, спортын төрийн бодлогыг хэрэгжүүлэх, өсвөрийн шигшээ багуудын сургалт дасгалжуулалтын орчин нөхцөлийг сайжруулах, дотоодын болон олон улсын тэмцээн уралдааныг зохион байгуулах, спортын барилга байгууламжийг нэмэгдүүлэх ажлуудыг зохион байгуулж Баянгол, Баянзүрх, Налайх, Чингэлтэй, Сүхбаатар дүүргүүдэд баригдаж буй спорт цогцолборын барилгын ажлыг үргэлжлүүлж, 20-85%-тай гүйцэтгэлтэй болсон. Монгол улсад анх удаа олон улсын стандартад нийцсэн хөнгөн атлетикийн 400 метр бүхий гүйлтийн тартан замыг Нийслэлийн Спортын хорооноос санаачлан Налайх дүүрэгт бариулахаар байршлыг шийдвэрлүүлж, мэргэжлийн зөвлөгөө өгч, БСШУСЯ, НЗДТГ, Налайх дүүргийн ЗДТГ, БТСХ, Олон улсын хөнгөн атлетикийн холбоо, Итали улсын “Mondo” компани зэрэг байгууллагуудтай хамтран ажилласан. Байгууламжийн гүйцэтгэгч байгууллагаар “Дэрэн наран” ХХК ажиллаж 2018 онд ашиглалтад оруулсан.</p>				

Нийслэлийн хүүхэд залуучуудын бие бялдрыг хөгжүүлэх, спортоор хичээллэх дур сонирхолтой болгох, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх ажлын хүрээнд 2018 онд нийслэлийн хэмжээнд 30 спортын талбайг 1869.8 сая төгрөгөөр, биеийн тамир, чийрэгжүүлэлт, хүүхдийн тоглоомын талбай 74-ийг 3025.3 сая төгрөгөөр, ногоон байгууламж бүхий бичил цэцэрлэгт хүрээлэн 17-г 1645.7 сая төгрөгөөр, дугуйн зам 1 байршилд, явган хүний алхалт, гүйлтийн 1.07 км зам 2 байршилд тус тус шинээр байгуулагдсан.

**2019 онд:** Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж “Улаанбаатар марафон”, Нийслэлийн иргэдийн спортын VIII наадам, “Мөнгөн Улаанбаатар” өвлийн наадам, Хотын захирагчийн нэрэмжит “Улаанбаатар лиг” ЕБС-ийн сурагчдын волейбол, сагсан бөмбөгийн тэмцээн, Нийслэлийн аварга шалгаруулах хөлбөмбөгийн “UB cup”, хөл бөмбөгийн “Дуулиан 2020” зэрэг олон нийтийг хамруулсан биеийн тамир, спортын 697 арга хэмжээг иргэдийн нас насны онцлогт тохируулан зохион байгуулж 955.017 иргэдийг хамруулсан. Нийслэлийн иргэдэд биеийн тамир, спортын үйлчилгээг хүртээмжтэй хүргэх үйл ажиллагааны хүрээнд хүний нөөц боловсон хүчний чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор нийслэлийн хэмжээнд 66 удаагийн сургалтыг зохион байгуулж 3478 хүнийг хамруулаа. Нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын хороодын орон тоог 6-аар нэмэгдүүлж цалингийн асуудлыг шийдвэрлүүлсэн.

Биеийн тамир, спортын төрийн бодлогыг хэрэгжүүлэх, өсвөрийн шигшээ багуудын сургалт дасгалжуулалтын орчин нөхцлийг сайжруулах, спортын барилга байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр улсын төсвийн хөрөнгөөр нийслэл болон Баянгол, Баянзүрх, Налайх, Чингэлтэй, Сүхбаатар дүүргүүдэд баригдаж буй спорт цогцолборын барилгын ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэлийн ажил 30-95%-тай болсон.

Налайх дүүрэгт 2018 онд барьж ашиглалтад оруулсан олон улсын стандартад нийцсэн хөнгөн атлетикийн 400м-ийн гүйлтийн тартан замыг тойруулан нийслэлийн хөрөнгөөр сүүдрэвч барьж, задгай цэнгэлдэх хүрээлэн болгон ашиглалтыг сайжрууллаа.

Нийслэлийн хүүхэд, залуучуудын бие бялдрыг хөгжүүлэх, спортоор хичээллэх дур сонирхолтой болгох, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх орчин нөхцөлийг сайжруулах ажлын хүрээнд 2019 онд нийслэлийн хэмжээнд 29 спортын талбайг 2457,8 сая төгрөгөөр, биеийнтамир, чийрэгжүүлэлт, хүүхдийн тоглоомын талбай 154-ийг 6690.9 сая төгрөгөөр, ногоон байгууламж бүхий бичил цэцэрлэгт хүрээлэн 14-г 2448.0 сая төгрөгөөр, дугуйн зам 1 байршилд, явган хүний алхалт, гүйлтийн 24.13 км замыг 10 байршилд тус тус шинээр байгуулсан.

**2020 онд:** "Нийслэлд биеийн тамир, спортыг 2017-2020 онд хөгжүүлэх дэд хөтөлбөр"-ийн 4 зорилт бүхий 19 үйл ажиллагааны хэрэгжилтийн тайланг хагас, бүтэн жилээр тайлагнаж байгууллагын даргын дэргэдэх удирдлагын зөвлөлөөр 4 удаа хэлэлцүүлж, хяналт-шинжилгээ үнэлгээ хийлгэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хугацаанд нь хүргүүлж ажиллаа. 2017-2020 онд Чингэлтэй дүүргийн БТСХ-ны спорт цогцолбор, Налайх дүүрэгт олон улсын стандартад нийцсэн Хөнгөн атлетикийн 400 метр бүхий гүйлтийн тартан зам, Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд 25 га-д Экстрим спортын талбай, байт харвааны стандартын талбай зэрэг томоохон бүтээн байгуулалтыг ашиглалтад оруулж нийслэлийн иргэдийг спортоор хичээллэх таатай боломжийг бүрдүүлсэн.Түүнчлэн нийслэлийн 13 байршилд спорт цогцолбор болон олон улсын стандартад нийцсэн спортын томоохон барилга байгууламжууд 30-98 хувийн гүйцэтгэлтэй баригдаж байгаа бөгөөд эдгээр спортын цогцолборууд ашиглалтад орсноор олон улс, тив, дэлхийн чанартай спортын арга хэмжээг зохион байгуулах орчин нөхцөл бүрдэж 2020 онд “Азийн хүүхдүүд-2020”, 2023 онд Зүүн Азийн залуучуудын II наадам"-уудыг нийслэл хотод зохион байгуулах эрхийг авч бэлтгэл ажлын 90%-ийг хангасан байна.

Нийслэлд иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөл сайжирч, 2018 оны судалгаагаар спортын барилга байгууламжийн хүртээмж 1000 хүн тутамд биеийн тамирын 60 м2 талбай оногдож байсан бол 2020 онд 1000 хүн тутамд 62 м2 болж 2 м2-аар нэмэгдүүлсэн байна. Биеийн тамир, спортын төрийн бодлогыг хэрэгжүүлэх, өсвөрийн шигшээ багуудын сургалт дасгалжуулалтын орчин нөхцөлийг сайжруулах, спортын барилга байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр улсын төсвийн хөрөнгөөр нийслэл болон Баянгол, Баянзүрх, Налайх, Чингэлтэй, Сүхбаатар дүүргүүдэд баригдаж буй спорт цогцолборын барилгын ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэлийн ажил 30-98%-тай болсон. Тив дэлхийн томоохон наадмуудыг зохион байгуулах туршлага хуримтлуулах зорилгоор жилд дунджаар 5 удаа олон улсын, тив, дэлхийн тэмцээнүүдийг зохион байгуулсан. Дотооддоо нийслэл, дүүргийн аварга шалгаруулах тэмцээнүүдийг жилд дунджаар 254 удаа зохион байгуулж нийт 298720 тамирчдыг хамруулсан.

		<p>Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийн хангаж Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/118 дугаар захирамжийн дагуу нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын захирамжаар Засаг даргын дэргэд өсвөрийн шигшээ багийг спортын 22-23 төрлөөр, 2695 тамирчин, 82 дасгалжуулагчтайгаар зохион байгуулж орон нутгийн төсөв болон дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгө, бусад эх үүсвэрээс жилд дунджаар 400 гаруй сая төгрөгийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлж, сургалт дасгалжуулалтыг зохион байгуулж өндөр зэрэгтэй тамирчдын залгамж халааг тасралтгүй бэлтгэж байна. Иргэдэд үзүүлэх үйлчилгээ болон спортод хандах бүх нийтийн хандлагыг сайжруулах чиглэлээр биеийн тамирын 795 хамтлагийг байгуулан мэргэжлийн удирдлагаар ханган ажиллаж, жил бүрийн дунджаар нийслэлийн хэмжээнд биеийн тамирын 443 арга хэмжээг зохион байгуулж 756451 иргэдийг хамруулж, нийслэлийн иргэдийн 52 хувь буюу суурь түвшинээс 3 хувиар өссөн дүнтэй гарч байна. Нийслэлийн хэмжээнд 2017-2020 онд нийт 93 км дугуйн зам шинээр баригдснаас 2020 онд 16 байршилд 352 км дугуйн замууд баригдахаар төлөвлөлт хийгдэж төсөв санхүүжилт батлагдан хэрэгжиж эхлээд байна.</p>				
	Үр дүн	<p>Нийслэлийн иргэдэд нийтийн биеийн тамир, спортын үйлчилгээг хүртээмжтэй хүргэх, хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх зорилгоор иргэдийн нас биений онцлогт тохируулан биеийн тамир, спортын 697 арга хэмжээг зохион байгуулж 955.017 хүнийг хамруулсан. Багш, дасгалжуулагч, арга зүйч мэргэжилтнүүдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтыг 66 удаа зохион байгуулж 3478 хүнийг хамруулсан. Нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын байгууллагуудын орон тоо 6-иар нэмэгдсэн. Нийслэлийн иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэх ажлын хүрээнд нийслэлд шинээр спортын талбай 59, биеийн тамир, чийрэгжүүлэлтийн талбай 228, ногоон байгууламж бүхий бичил цэцэрлэгт хүрээлэн 31, дугуйн зам 16 байршилд, явган алхалт гүйлтийн 93км зам шинээр байгуулагдаж байна. Нийслэл болон дүүргүүдэд баригдаж байгаа спортын цогцолборуудын ажлын гүйцэтгэл 30-98 хувьтай явж байна.</p>				
		<p><b>"Улаанбаатар Марафон" олон улсын гүйлтийн тэмцээн, Нийслэлийн иргэдийн спортын наадмыг олон төрлөөр жил бүр өргөн хүрээнд зохион байгуулна.</b></p>	НСХ	Ш.Анхмаа	100%	100%
3	4.4.3	<p>"Улаанбаатар Марафон" олон улсын гүйлтийг жил бүр 05 дугаар сарын 3 дахь 7 хоногийн амралтын өдрүүдэд Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулдаг уламжлалын дагуу 2017-2019 оны хооронд жил бүр 30-32 мянган иргэдийг хамруулсан байна. Үүнд:</p> <p><b>2017 онд:</b> "Улаанбаатар марафон" олон улсын гүйлтийг 1.5 км, 5 км, 10 км, 21 км, 42 км гэсэн 5 зайд эр, эм тус бүр 10 насны ангиллаар зохион байгуулж 32000 гаруй гаруй гүйгч, гадаадын 29 орны 300 гаруй тамирчид, гүйгчид оролцсон. Гүйлтэд амжилттай оролцсон 161 иргэнийг цом, медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал, ивээн тэтгэгч байгууллагуудын гарын бэлгээр шагнаж урамшуулсан. Олон улсын гүйлтийг зохион байгуулахад нийт 178.970.000 төгрөг зарцуулснаас Нийслэлийн төсвөөс 158.970.000 төгрөг, бусад эх үүсвэрээс 20.000.000 төгрөг зарцуулсан.</p> <p><b>2018 онд:</b> "Улаанбаатар Марафон-2018" олон улсын гүйлтийг 1.5 км, 5 км, 10 км, 21 км, 42 км гэсэн 5 зайд эр, эм тус бүр 10 насны ангиллаар зохион байгуулж 30000 гаруй гүйгч, үүнээс 30 орны 400 гаруй гадаад тамирчид, гүйгчид бүртгүүлэн оролцсон. Гүйлтэд амжилттай оролцсон 139 иргэнийг цом, медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал, ивээн тэтгэгч байгууллагуудын гарын бэлгээр шагнаж урамшуулсан. Олон улсын гүйлтийг зохион байгуулахад 187.800.000 төгрөг нийслэлийн төсвөөс, /20 сая төгрөг бүртгэлийн хураамжнаас/зарцуулсан.</p> <p><b>2019 онд:</b> "Улаанбаатар Марафон-2019" олон улсын гүйлтийг 1.5 км, 5 км, 10 км, 21 км, 42 км гэсэн 5 зайд эр, эм тус бүр</p>				

		<p>10 насны ангиллаар зохион байгуулж 32000 гаруй гүйгч,гадаадын 29 орны 313 тамирчид, гүйгчид хамрагдсан. Гүйлтэд амжилттай оролцсон 131 иргэнийг цом, медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал, ивээн тэтгэгч байгууллагуудын гарын бэлгээр шагнаж урамшуулсан. Олон улсын гүйлтийг зохион байгуулахад шаардагдах зардлын 181.940.000 төгрөгийг нийслэлийн төсвөөс /40.0 сая төгрөг бүртгэлийн хураамжаас/ зарцуулсан.</p> <p><b>2020 онд:</b> “Улаанбаатар марафон-2020” олон улсын гүйлтийг 2020 оны 05 дугаар сарын 22-нд зохион байгуулахаар төлөвлөж бэлтгэл ажлыг хангасан боловч дэлхий нийтэд тархаад байгаа “Covid-19” цар тахал буюу коронавирусээс урьдчилан сэргийлэх зорилгоор гаргасан Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн “Шинэ коронавирусийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 30 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн “Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/108 дугаар захирамжаар олон нийтийг хамарсан спортын тэмцээн, уралдаан зохион байгуулахыг хориглосон тул арга хэмжээг хойшлуулаад байсан. Коронавирусын халдвар дахинд дэгдсэнтэй холбоотойгоор Засгийн Газрын 2020 “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 159, “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 178, “Бэлэн байдлын зэргийг бууруулах тухай” 209 дүгээр тогтоол, Улсын онцгой комиссын 2020 оны 34 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны “Коронавируст /Ковид-19/ цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай” А/1241, Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай А/1242, Гамшгаас хамгаалах Бүх нийтийн бэлэн байдлын зэргийг бууруулсантай холбогдуулан хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай А/1280 дугаар захирамжуудаар олон нийтийг хамарсан спортын тэмцээн, уралдаан зохион байгуулахыг хориглосон тул явуулах боломжгүй болсон.</p> <p>Нийт: <b>2017-2019 онд:</b> Олон улсын гүйлтийг зохион байгуулж 98800 хүнийг хамруулсан бөгөөд зохион байгуулалтын зардалд Нийслэлийн Засаг даргын нөөц сан, Зүүн хойд Азийн бизнес аялал жуучлал, соёл, санхүүгийн төв болох арга хэмжээний зардлаас, Нийслэлийн Спортын хорооны батлагдсан төсвөөс, марафоны хураамжаас 548.710.000 төгрөгийг зарцуулсан байна.</p>										
	<b>Үр дүн</b>	<p>Марафонд оролцогчдын тоо жилээс жилд өсөн нэмэгдэж, жил бүр 30-32 мянган гүйгчид тогтмол оролцдог болсон бөгөөд 2016 онтой харьцуулахад оролцогчдын тоо 50 хувиар өсөж, гадаадын улс орнуудаас оролцогчдын тоо 400 болсон нь 2016 онтой харьцуулахад 2 дахин нэмэгдсэн байна.</p>										
4	4.4.4	<table border="1"> <tr> <td data-bbox="369 1086 1355 1157"><b>Нийслэлийн Засаг даргын нэрэмжит “Мөнгөн Улаанбаатар” өвлийн наадмыг жил бүр зохион байгуулна.</b></td> <td data-bbox="1355 1086 1482 1157"><b>НСХ</b></td> <td data-bbox="1482 1086 1673 1157"><b>Ш.Анхмаа</b></td> <td data-bbox="1673 1086 1899 1157"><b>90%</b></td> <td data-bbox="1899 1086 2083 1157"><b>100%</b></td> </tr> <tr> <td colspan="5" data-bbox="369 1157 2083 1267">Нийслэлийн хүн амын дунд зохион байгуулах биеийн тамир, спортын үйл ажиллагааг эрчимжүүлэх, өвлийн улиралд Улаанбаатар хотод ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын нэрэмжит “Мөнгөн Улаанбаатар” өвлийн наадмыг жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг болсон.</td> </tr> </table>	<b>Нийслэлийн Засаг даргын нэрэмжит “Мөнгөн Улаанбаатар” өвлийн наадмыг жил бүр зохион байгуулна.</b>	<b>НСХ</b>	<b>Ш.Анхмаа</b>	<b>90%</b>	<b>100%</b>	Нийслэлийн хүн амын дунд зохион байгуулах биеийн тамир, спортын үйл ажиллагааг эрчимжүүлэх, өвлийн улиралд Улаанбаатар хотод ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын нэрэмжит “Мөнгөн Улаанбаатар” өвлийн наадмыг жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг болсон.				
<b>Нийслэлийн Засаг даргын нэрэмжит “Мөнгөн Улаанбаатар” өвлийн наадмыг жил бүр зохион байгуулна.</b>	<b>НСХ</b>	<b>Ш.Анхмаа</b>	<b>90%</b>	<b>100%</b>								
Нийслэлийн хүн амын дунд зохион байгуулах биеийн тамир, спортын үйл ажиллагааг эрчимжүүлэх, өвлийн улиралд Улаанбаатар хотод ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын нэрэмжит “Мөнгөн Улаанбаатар” өвлийн наадмыг жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг болсон.												

**2017 онд:** Нийслэл, дүүргийн нутгийн захиргааны байгууллагын ажилтан, албан хаагчдын өвлийн улиралд зохион байгуулах “Мөнгөн Улаанбаатар” биеийн тамир, спортын үйл ажиллагааны “Цасны баяр”-ын нээлтийн өдөрлөгийг “Хүй долоон худагт” зохион байгуулж нийт 200 байгууллагын 10.000 хүнийг хамруулсан. “Цасны баяр”-ын арга хэмжээнд Нийслэлийн Засаг даргын нөөц сангаас 10.233.200 төгрөг зарцуулсан.

“Мөнгөн Улаанбаатар” өвлийн спортын наадмын хүрээнд нийслэлийн дүүргүүдэд “Цасны баяр”-ыг нийт 14 удаа зохион байгуулж 367 байгууллагын 10171 ажилтан, албан хаагч нарыг хамруулсан.

Өвлийн улиралд Улаанбаатар хотод ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх, зорилгоор Нийслэлийн Аялал жуучлалын газартай хамтран Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд өвлийн өдөрлөгийг 2 өдөр зохион байгуулж гэр бүлийн буухиа, олс таталтын тэмцээнд 153 иргэдийг хамруулсан.

Нийслэлийн иргэд, хүүхэд, залуучуудыг өвлийн улиралд амралт, чөлөөт цагаа ая тухтай өнгөрүүлэх, орчин нөхцөлийг сайжруулах ажлын хүрээнд аж ахуй нэгж, байгууллагуудын санаачлагыг дэмжин ажилласны үр дүнд Богины ам, Хандгайт, Sky resort, UB resort, Багануур дүүргийн цанын баазууд тогтмол үйл ажиллагаа явуулж 2016 оны IV улирлаас 2017 оны эхний улиралд 58000 гаруй хүнд үйлчилгээ үзүүлсэн байна.

Нийслэлийн хэмжээнд орон сууц, гэр хороолол, ЕБС-иудын гадна талбайд 47 мөсөн гулгуурын талбай байгуулагдан ажиллаж 330.000 гаруй иргэдэд үйлчилгээ үзүүлсэн.

“Мөнгөн Улаанбаатар” өвлийн спортын наадмын хүрээнд дүүргүүдийн болон Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнийг 3 удаа /тэшүүр, цана, мөсөн хадны авиралт/ зохион байгуулж 47 байгууллагын 240 тамирчид оролцуулсан.

**2018 онд:** “Мөнгөн Улаанбаатар” өвлийн наадмын “Цасны баяр” арга хэмжээг 2018 оны 02 дугаар сарын 24-ний өдөр Хандгайтын “Янзага” зусланд зохион байгуулж Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Нутгийн захиргааны байгууллагууд, агентлагууд, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, түүний харьяа байгууллагууд, Нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын хороод зэрэг 200 гаруй байгууллагын 10000 гаруй ажилтан, албан хаагчид, иргэдийг хамрууллаа. “Мөнгөн Улаанбаатар” өвлийн спортын наадмын хүрээнд нийслэлийн дүүргүүдэд цасны баярыг нийт 8 удаа зохион байгуулж 8601 иргэдийг харууллаа. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Аялал жуулчлалын газраас 2018 оны 02 дугаар сарын 05-06-ны өдрүүдэд “Улаанбаатар Өвлийн наадам- 2018” арга хэмжээг зохион байгуулж гэр бүлийн буухиа, олс таталтын тэмцээнийг манай байгууллага хариуцан иргэдийн дунд зохион байгуулж 112 иргэнийг хамруулсан. Монголын уламжлалт үндэсний спортын төрлүүд, уламжлалт тоглоом, зан үйл, ёс заншил, соёлыг өсвөр залуу үеийнхэнд өвлүүлэн сургах зорилгоор үндэсний спортын их наамдыг Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд Мөсний шагай, Мөсний сурын харвааны төрлөөр зохион байгуулж 504 тамирчин оролцлоо. Нийслэлийн иргэд, хүүхэд, залуучуудыг өвлийн улиралд амралт, чөлөөт цагаа ая тухтай өнгөрүүлэх, орчин нөхцөлийг сайжруулах ажлын хүрээнд аж ахуй нэгж, байгууллагуудын санаачилгыг дэмжин ажилласны үр дүнд Богины ам, Хандгайт, Sky resort, Багануур дүүргийн цанын баазууд, орон сууц, гэр хороолол, ЕБС-иудын гадна талбайд 40 мөсөн гулгуурын талбай байгуулагдан ажиллаж 400.000 мянга гаруй иргэдэд үйлчилгээ үзүүлж ажилласан. Нийслэлийн иргэд, хүүхэд, залуучуудыг өвлийн улиралд амралт, чөлөөт цагаа ая тухтай өнгөрүүлэх, орчин нөхцөлийг сайжруулах ажлын хүрээнд аж ахуй нэгж, байгууллагуудын санаачилгыг дэмжин ажилласны үр дүнд Богины ам, Хандгайт, Sky resort, Багануур дүүргийн цанын баазууд, орон сууц, гэр хороолол, ЕБС-иудын гадна талбайд 40 мөсөн гулгуурын талбай байгуулагдан ажиллаж 400.000 мянга гаруй иргэдэд үйлчилгээ үзүүлж ажилласан.

Нийслэлийн иргэд, хүүхэд, залуучуудыг өвлийн улиралд амралт, чөлөөт цагаа ая тухтай өнгөрүүлэх, орчин нөхцөлийг сайжруулах ажлын хүрээнд аж ахуй нэгж, байгууллагуудын санаачилгыг дэмжин ажилласны үр дүнд Богинын ам, Хандгайт, Sky resort, Багануур дүүргийн цанын баазууд, орон сууц, гэр хороолол, ЕБС-иудын гадна талбайд 40 мөсөн гулгуурын талбай байгуулагдан ажиллаж 400.000 мянга гаруй иргэдэд үйлчилгээ үзүүлж ажилласан. 2017 оны IV улиралд Сэлбэ голын дунд хэсэг Скай их дэлгүүрийн баруун талд стандартын шаардлагад нийцсэн иж бүрэн тохижуулсан мөсөн гулгуурын талбай /мөсөн хотхон/ байгуулахад мэргэжил арга зүйн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, хамтран ажилласан. “Мөнгөн Улаанбаатар” өвлийн наадмын хүрээнд Улаанбаатар хотын аварга шалгаруулах Өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчдийн Тэшүүрийн тэмцээнийг 2018 оны 01 дүгээр сарын 20-21-ний өдрүүдэд Хандгайт дахь мөсөн гулгуурын талбайд зохион байгуулж 14 байгууллагын 60 тамирчин оролцлоо.

“Мөнгөн Улаанбаатар” өвлийн наадамд нийт 418.713 иргэнийг хамруулан 11.929.900 төгрөг зарцуулсан байна.

**2019 онд:** “Улаанбаатар өвлийн наадам-2019” арга хэмжээний хүрээнд гэр бүлийн буухиа тэмцээн, олс таталтын тэмцээнийг 2019 оны 02 дугаар сарын 16, 17-ны өдрүүдэд зохион байгуулж 172 иргэдийг хамруулсан байна. “Дэлхийн цасны өдөр”-ийг 2019 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр Sky resort цанын баазад “Монголын Цанын холбоо”-той хамтран зохион байгуулж 2000 гаруй иргэдийг хамруулсан. Улаанбаатар хотын аварга шалгаруулах гүйлтийн тэшүүрийн тэмцээнийг 2019 оны 02 дугаар сарын 16-17-ны өдрүүдэд Хандгайтын 400м стандартын мөсөн гулгуурын талбайд 14 байгууллагын 106 тамирчдыг оролцуулсан байна. 2019 онд Богинын ам, Хандгайт, Sky resort, UB resort, БНД-ийн цанын баазууд үйл ажиллагаа явуулж 2018 оны IV улирлаас 2019 оны I улиралд 59000 гаруй хүнд үйлчилгээ үзүүлсэн. Орон сууц, гэр хороолол, ЕБС-иудын гадна талбайд 28 мөсөн гулгуурын талбай байгуулагдан 250.000 гаруй иргэдэд үйлчилгээ үзүүлсэн байна. **Нийт:** “Мөнгөн Улаанбаатар” өвлийн наадмын хүрээнд 312.316 иргэнийг хамруулсан байна.

**2020 онд:** Нийслэлийн хүн амын дунд зохион байгуулах биеийн тамир, спортын үйл ажиллагааг эрчимжүүлэх, өвлийн улиралд Улаанбаатар хотод ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын нэрэмжит “Мөнгөн Улаанбаатар” өвлийн наадмыг жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг болсон. Нийслэлийн иргэдийн бие бялдрыг өвлийн спортын төрлөөр дамжуулан хөгжүүлэх зорилгоор “Мөнгөн Улаанбаатар” өвлийн наадмыг 2017-2019 онд жил бүр зохион байгуулж 40-50 мянган иргэдийг хамруулсан байна. Дэлхий нийтэд тархаад байгаа “Covid-19” цар тахал буюу коронавирусаас урьдчилан сэргийлэх зорилгоор гаргасан Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн “Шинэ коронавирсийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 30 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны “Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/108 дугаар захирамжийн хүрээнд тодорхойгүй хугацаагаар хойшлуулаад байсан боловч Коронавирсын халдвар дахин дэгдсэнтэй холбоотойгоор Засгийн Газрын 2020 “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 159, “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 178, “Бэлэн байдлын зэргийг бууруулах тухай” 209 дүгээр тогтоолууд, Улсын онцгой комиссын 2020 оны 34 дүгээр тогтоол,

Нийслэлийн Засаг даргын 2020 оны “Коронавируст /Ковид-19/ цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай” А/1241, Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай А/1242, Гамшгаас хамгаалах Бүх нийтийн бэлэн байдлын зэргийг бууруулсантай холбогдуулан хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай А/1280 дугаар захирамжуудаар олон нийтийг хамарсан спортын арга хэмжээг зохион байгуулахыг хориглосон тул арга хэмжээг явуулах боломжгүй болсон.



<b>Үр дүн</b>	Нийслэлийн иргэдийн бие бялдрыг өвлийн спортын төрлөөр дамжуулан хөгжүүлэх зорилгоор “Мөнгөн Улаанбаатар” өвлийн наадмыг 2017-2019 онд жил бүр зохион байгуулж 40-50 мянган иргэдийг хамруулсан байна. Өвлийн улиралд жил бүр Улаанбаатар хотод 50 гаруй мөсөн гулгуурын талбай байгуулж 350-400 мянган иргэдэд үйлчилгээ үзүүлж байна.					
<b>5</b>	<b>4.4.5</b>	<b>Идэвхтэй хөдөлгөөнд суурилсан явган болон дугуйн аялал, алхалт, гүйлт, иог, фитнесээр хичээллэх иргэдийн орчин нөхцөлийг бүрдүүлж, бодлогоор дэмжинэ.</b>	<b>НСХ</b>	<b>Ш.Анхмаа</b>	<b>100%</b>	<b>100%</b>
		<p>Идэвхтэй хөдөлгөөнд суурилсан явган болон дугуйн аялал, алхалт, гүйлт, иог, фитнесээр хичээллэх орчин нөхцөлийг сайжруулах асуудлыг “Нийслэлд биеийн тамир, спортыг 2017-2020 онд хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийн 2 дугаар зорилтод тусган хэрэгжүүлж байна.</p> <p><b>2017 онд:</b> Иргэдийн идэвхтэй хөдөлгөөнийг дэмжин зохион байгуулдаг “Дөрвөн хайрханаа дээдэлье” эко явган явлалд 9 дүүргийн 120 иргэд, Иргэдийн спортын VI наадмын “Спорт явган аялал”-ын тэмцээнд 9 дүүрэг 152 хорооноос шалгарсан 9 хороодын 117 тамирчин оролцсон. Чингэлтэй, Хан-Уул, Сонгинохайрхан, Багахангай, Багануур дүүргийн Биеийн тамир, спортын хорооны дэргэдэх клуб, ахмадын төв, спорт заал, бялдаржуулах танхимд иргэд гэрээ байгуулан нас, цаг харгалзахгүй спортын олон төрлөөр хичээллэсэн.Нийслэлийн хэмжээнд 2017 онд 19 спорт холбоотой ажиллах гэрээ байгуулан 26 спортын уралдаан тэмцээн, 36 нийтийн биеийн тамирын арга хэмжээнд хамтарч ажилласан.</p> <p><b>2018 онд:</b> Нийслэлийн иргэдийг хөдөлгөөний хомсдолоос үүдэлтэй халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн “Дөрвөн хайрханаа дээдэлье” явган аялал, “Дэлхийн алхалтын өдөр”, “Дэлхийн иогийн өдөр”, “Авто машингүй өдөр”-үүдийг спортын холбоод, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж байна. Явган аялал, алхалт, гүйлт, иог, фитнес болон оюуны спортын төрлүүдээр 5 удаа сургалт зохион байгуулж 40-45 мянган иргэдийг хамруулсан байна. Дүүргүүдийн хороодод явган алхалт, гүйлт, хийн дасгал, аэробик, граунд гольф, сагсан бөмбөг, волейбол зэрэг 10 гаруй спортын төрлүүдээр иргэдийн үүсгэл санаачлагаар багуудыг байгуулж мэргэжлийн удирдлагаар ханган ажилласан. Хороодын Иргэний танхимийг түшиглэн спортын 10 гаруй төрийн бус байгууллага байгуулагдан өдөр тутам идэвхтэй үйл ажиллагаа явуулсан байна. Иргэдийг бэлтгэл, сургуулилт хийх дасгал хөдөлгөөнөөр хичээллэх заал талбайгаар хангах асуудлыг дүүрэг хороодын Засаг дарга, тухайн хорооны нутаг дэвсгэрт байгаа ЕБС, ААНБ, Спортын хороодтой хамтран шийдвэрлэж, нөхцөл бололцоогоор ханган ажилласан байна.</p> <p><b>2019 онд:</b> Налайх, Багахангай, Чингэлтэй, Баянгол, Баянзүрх дүүргүүд иргэдийнхээ дунд 7 хоног, сар бүр гүйлт, алхалтыг тогтмол зохион байгуулан 161 байгууллагын 2379 иргэдийг хамруулсан байна. “Олон улсын иогийн өдөр”-ийг тохиолдуулан Нийслэлийн 6 дүүрэгт “Иог-Эв нэгдэл-Энх тайван” уриан дор “Оюун санааны нар” ТББ, “Монголын агаарын иогийн холбоо”,</p>				

		<p>“Ари Иог студио” байгууллагуудтай хамтран иогийн сургалтыг зохион байгуулж 150 иргэдийг хамруулсан. “Гимнастрада” уралдаант үзлэгийг 5 дахь жилдээ зохион байгуулж нийслэлийн 9 дүүргийн 27 байгууллагын <b>1043</b> иргэдийг оролцуулсан бөгөөд арга хэмжээг зохион байгуулахад улсын төсвөөс 10.400.000 төгрөгийг зарцуулсан байна.</p> <p>Нийслэлийн 380 жилийн ойд зориулан Нийслэлийн Засаг даргын ивээл дор Оюутан, залуучуудын дунд сагсан бөмбөг, волейболын тэмцээнийг зохион байгуулж 32 багийн 3200 оюутан залуучуудыг оролцуулж, иргэдийн дунд бүх нийтийн гүйлт, шатар, дугуйн парад, тэмцээнийг зохион байгуулж 4.411 иргэдийг хамруулсан. “Үзэсгэлэнт Улаанбаатарын цом” өртөөт марафоныг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газартай хамтран Багануур дүүрэгт 3 насны ангиллаар зохион байгуулж 9 дүүргийн 400 гаруй иргэд, оюутан, сурагчдыг оролцуулсан.</p> <p>Нийт жил бүр идэвхтэй хөдөлгөөнд суурилсан явган болон дугуйн аялал, алхалт, гүйлт, иог, фитнесээр хичээллэх иргэдийн орчин нөхцөлийг бүрдүүлэх үүднээс давхардсан тоогоор 50.000 гаруй иргэдийг хамруулдаг байна.</p> <p><b>2020 онд:</b> Идэвхтэй хөдөлгөөнд суурилсан явган болон дугуйн аялал, алхалт, гүйлт, иог, фитнесээр хичээллэх орчин нөхцөлийг сайжруулах асуудлыг “Нийслэлд биеийн тамир, спортыг 2017-2020 онд хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийн 2 дугаар зорилтод тусган хэрэгжүүлж байна. Нийт жил бүр идэвхтэй хөдөлгөөнд суурилсан явган болон дугуйн аялал, алхалт, гүйлт, иог, фитнесээр хичээллэх иргэдийн орчин нөхцөлийг бүрдүүлэх үүднээс давхардсан тоогоор 50.000 гаруй иргэдийг хамруулдаг байна. Энэ жилийн хувьд “Ковид-19” цар тахлын үед иргэдийг идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр хичээллэх нөхцөл боломжоор хангах, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх зорилгоор Нийслэлийн засаг даргын санаачлагаар нийслэлийн 9 дүүргийн 63 хороонд нийтийн эзэмшлийн болон ногоон байгууламж бүхий спортын талбайд нийтийн дасгалын үйл ажиллагаа зохион байгуулж 15835 иргэдийг хамруулсан. Нийслэлийн Засаг даргын нэрэмжит “Дугуйн өдөр” арга хэмжээг 2020 оны 10 дугаар сарын 31-ний өдөр Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд дугуйн парад, уралдаан гэсэн хэлбэрээр 11:00–17:00 цагийн хооронд зохион байгуулж, сонирхогчид болон иргэд, мэргэжлийн дугуйчдын дунд ердийн дугуй, уулын дугуйн уралдаан тэмцээнүүдийг олон насны ангиллаар явуулж 500 гаруй дугуйчид, сонирхогчид оролцлоо. Тус арга хэмжээг 2020 оны 9 дүгээр сард төлөвлөсөн боловч дэлхий нийтэд тархаад байгаа “Covid-19” цар тахал буюу коронавирусаас урьдчилан сэргийлэх зорилгоор гаргасан Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн “Шинэ коронавирусийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 30 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны “Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/108 дугаар захирамжийн хүрээнд хойшлогдож 10 сард зохион байгуулсан тул цаг агаарын хүнд нөхцөлөөс хамаарч хамрагдах хүний тоо буурсан.</p>				
	Үр дүн	<p>Дүүргийн хороодод иргэдийн үүсгэл санаачлалаар 10 гаруй спортын төрлөөр багуудыг байгуулсан. Иргэний танхимыг түшиглэн биеийн тамир, спортын 10 гаруй төрийн бус байгууллага байгуулагдан өдөр тутам идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг болсон. Иргэдийг идэвхтэй дасгал хөдөлгөөн, спортоор хичээллэх заал талбайгаар хангах асуудлыг дүүрэг, хороодын Засаг дарга, тухайн хорооны нутаг дэвсгэрт байгаа ЕБС, ААНБ, Спортын хороодтой хамтран шийдвэрлэж ажилласан.</p>				
6	4.4.6	<p><b>Нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг өргөжүүлж, дэмжлэг үзүүлнэ.</b></p>	НСХ	Ш.Анхмаа	100%	100%

		<p>Биеийн тамир, спортын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5 дах заалтад заасны дагуу Нийслэл, дүүрэгт өсвөрийн шигшээ багийг байгуулж, дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд</p> <p><b>2017 онд:</b> Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Оюутны шигшээ багийг спортын 7 төрлөөр 23 тамирчинтай байгуулж үйл ажиллагаанд зориулж нийслэлийн төсвөөс 76.666.221 төгрөг зарцуулсан. Тамирчид тив, дэлхий, олон улс, бүсийн тэмцээнүүдээс 22 алт, 16 мөнгө, 4 хүрэл нийт 42 медаль хүртсэн амжилтыг үзүүлсэн. Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийг спортын 22төрлөөр 1908 тамирчны бүрэлдэхүүнтэй байгуулж үйл ажиллагаа явуулсан ба өсвөрийн шигшээ багийн тамирчид улс, олон улс, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнүүдээс нийт 1655 медаль хүртсэн амжилтыг үзүүлсэн.</p>
		<p><b>2018 онд:</b> Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2017 оны 07 дугаар сарын 06-нд батлагдсанаар Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Оюутны шигшээ баг 2018 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс татан буугдсан. Тамирчдын залгамж халааг бэлтгэх зорилгоор дүүргүүдийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийг 23 төрлөөр 68 дасгалжуулагч 1610 тамирчдын бүрэлдэхүүнтэй хичээллүүлэн тамирчдын бэлтгэл сургуулилтад нийслэлийн төсвөөс нийт 609.566.350 төгрөг зарцуулсан байна. Олон улс, тив, дэлхий, улсын аварга шалгаруулах тэмцээнүүдээс өсвөрийн шигшээ багийн тамирчид нийт 1676 медаль хүртэж амжилтаа ахиулсан.</p> <p><b>2019 онд:</b> Нийслэлийн 9 дүүргийн Засаг дарга нарын дэргэдэх өсвөрийн шигшээ баг спортын 22 төрлөөр 82 дасгалжуулагч 2695 тамирчдын бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулсан. Дүүргүүдийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийн сургалт дасгалжуулалтад зориулж 9 дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Дүүргийн Засаг даргын захирамжаар 36.900.000 төгрөг, орон нутгийн төсвөөс 219.299.110 төгрөг, бусад эх үүсвэрээс 74.939.000 төгрөг, нийт 331.138.110 төгрөг зарцуулсан байна. Өсвөрийн шигшээ багийн тамирчид тив дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс 42, олон улсын тэмцээнээс 218, улс, нийслэл, дүүргийн тэмцээнээс 1.331 медаль, нийт 2085 медалийг хүртсэн амжилт үзүүлсэн. Дүүргүүдийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ баг 1.017.370.681 төгрөгийг зарцуулснаар олон улс, тив, дэлхий, улсын аварга шалгаруулах тэмцээнүүдээс тамирчид 3 жилийн хугацаанд нийт 5458 медаль хүртэж амжилт жилээс жилд нэмэгдсэн байна.</p> <p><b>2020 онд:</b> Өсвөрийн шигшээ баг 2020 онд спортын 22 төрлөөр 82 дасгалжуулагч 2695 тамирчинтай, сургалт дасгалжуулалтаа явуулж, өндөр зэрэгтэй тамирчдын залгамж халааг тасралтгүй бэлтгэж ажиллалаа. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 30 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/108 дугаар захирамжаар олон нийтийг хамарсан спортын тэмцээн, уралдаан зохион байгуулахыг хориглосон тул Нийслэлийн Спортын хорооноос өгсөн үүрэг, чиглэлийн дагуу 2020 оны 02 дугаар сарын 01-ээс 09 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл өсвөрийн шигшээ багуудын багш, дасгалжуулагч нар хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу цахим зайн сургалтыг 480 удаа явуулж тамирчдын бэлтгэлжилтийг хангаж ажилласан. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 103 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1114</p>

		<p>дүгээр захирамжаар нийтийг хамарсан, олон нийтийн арга хэмжээг нээсэн тул 2020 оны 09 дүгээр сарын 14-ний өдрөөс 11 дүгээр сарын 10-ны өдөр хүртэл өсвөрийн шигшээ багийн тамирчид, дасгалжуулагч нар COVID-19 шинэ төрлийн корона вирусийн халдвараас сэргийлж, Нийслэлийн Засаг даргын захирамж, Улсын Онцгой байдлын комиссийн гаргасан тогтоол, шийдвэрийг дагаж мөрдөн, ариутгал халдваргүйжүүлэлт хийж, халууны хэмжилтийг тогтмол үзэж тодорхой тооны тамирчидтай заал, талбайд бэлтгэл, сургуулилтаа үргэлжлүүлэн хэвийн горимд шилжүүлэн ажилласан. Мөн 2020 онд хот, улсын аварга шалгаруулах тэмцээн болон олон улс, тив, дэлхийн тэмцээнүүдээс нийт 139 алт, 96 мөнгө, 103 хүрэл медаль хүртсэн амжилт үзүүллээ.Өсвөрийн шигшээ багт орон нутгийн төсвөөс 2020 онд нийт 122.878.800 төгрөг зарцуулсан байна.</p> <p>COVID-19 шинэ төрлийн корона вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор гаргасан Улсын онцгой комиссын 2020 оны 12 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1241 дүгээр захирамжаар спортын үйл ажиллагаануудыг хориглосон тул Нийслэлийн Спортын хорооноос өгсөн үүрэг, чиглэлийн дагуу 2020 оны 11 дүгээр сарын 11-ээс 12 дугаар сарын 30-ны өдөр хүртэл өсвөрийн шигшээ багуудын багш, дасгалжуулагч нар хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу 493 удаа цахим зайн сургалт явуулж тамирчдын бэлтгэлжилтийг ханган ажилласан.</p>				
	<b>Үр дүн</b>	<p>Биеийн тамир, спортын хуулийн дагуу тамирчдын залгамж халааг бэлтгэх зорилгоор Нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийг спортын 22-23 төрлөөр тамирчид 4 жилийн хугацаанд нийт 5796 медаль хүртэж амжилт жилээс жилд нэмэгдсэн байна.</p>				
		<b>Хотын захирагчийн нэрэмжит “Улаанбаатар лиг” ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын волейбол, сагсан бөмбөгийн тэмцээн, нийслэлийн аварга шалгаруулах хөлбөмбөгийн “UB cup” нээлттэй тэмцээнийг жил бүр зохион байгуулна.</b>	<b>НСХ</b>	<b>Ш.Анхмаа</b>	<b>100%</b>	<b>100%</b>
<b>7</b>	<b>4.4.7</b>	<p>Багийн спортыг дэмжих зорилгоор “Улаанбаатар лиг” сагсан бөмбөг, волейбол, “Дуулиан 2020” хөлбөмбөгийн тэмцээнийг нийслэлийн Засаг даргын нэрэмжит болгон жил бүр уламжлал болгон зохион байгуулж ирсэн. Давхардсан тоогоор 3 жилийн хугацаанд нийт давхардсан тоогоор 25.404 багийн 452.498 сурагчдыг хамруулсан байна. Үүнд:</p> <p><b>2017 онд:</b> Нийслэлийн ЕБС-ийн сурагчдын 2016-2017 оны хичээлийн жилийн “Улаанбаатар лиг” сагсан бөмбөг, волейболын тэмцээнийг 2-3 насны ангиллаар, 5 үе шаттайгаар зохион байгуулан 231 сургуулийн 8700 багийн 115729 сурагчдыг хамруулан, улсын төсвөөс 21.903.000 төгрөг зарцуулсан.</p> <p>“Дуулиан - 2020” хөлбөмбөгийн тэмцээнийг 10 насны ангиллаар 6 дүүргийн 1250 багийн 30000 сурагчдыг хамруулан зохион байгуулсан. Багийн спортын төрлийн тэмцээнүүдэд нийт 9950 багийн 145799 тамирчид хамрагдсан.</p> <p><b>2018 онд:</b> ЕБС-ийн сурагчдын сагсан бөмбөгийн “Улаанбаатар лиг” тэмцээнийг 3 насны ангиллаар 5 үе шаттайгаар зохион байгуулж нийслэлийн 9 дүүргийн 121 сургуулийн охид, хөвгүүдийн 6413 багийн 85000 гаруй сурагч хамрагдсан бол “Улаанбаатар лиг” Ниислэлийн шигшээ тэмцээнд бага, дунд, ахлах насны ангилал бүрийн охид, хөвгүүдийн топ 90 багийн 1344 сурагч оролцсон.</p>				

**2019 онд:** ЕБС-ийн сурагчдын “Улаанбаатар лиг” сагсан бөмбөгийн тэмцээнийг 3 насны ангиллаар 5 үе шаттай зохион байгуулж нийт 6413 багийн 85000 тамирчид хамрагдсан. ОХУ-ын Толляти хотод тус тэмцээний ахлах насны аваргаар шалгарсан охид, хөвгүүдийн 28 хүний бүрэлдэхүүнтэй баг тамирчид амжилттай оролцсон.

“Улаанбаатар лиг” волейболын тэмцээнийг 2 насны ангиллаар 3 үе шаттай зохион байгуулж 2287 багийн 30800 тамирчдыг хамруулсан.

“Дуулиан-2020” тэмцээн 3 үе шаттайгаар явагдсан бөгөөд нийт 87 сургуулийн давхардсан тоогоор 30,000 орчим охид, хөвгүүд 4 насны ангилалд оролцсон.

“UB CUP” хөлбөмбөгийн тэмцээнийг мэргэжлийн бус тамирчин, ажилчдын дунд зохион байгуулж 11 багийн 220 тамирчдыг хамруулсан.

**2020 онд:** Хотын захирагчийн нэрэмжит “Улаанбаатар лиг” сагсан бөмбөгийн тэмцээнийг Нийслэлийн 9 дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын хооронд бага /10-11 хүртэлх/ нас, дунд/11-14/ нас, ахлах /15-18/ нас 3 насны ангилалаар 2019 оны есдүгээр сараас 2020 оны нэгдүгээр сарын хооронд зохион байгуулж I-IV үе шаттай анхан шатны тэмцээнийг явуулж 9 дүүргийн 91 сургуулийн 85.000 сурагчдыг хамруулсан бөгөөд V дахь шат буюу Нийслэлийн шигшээ тэмцээнийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Спортын хороо, ОХУ-ын Школьная баскетбольная лига “КЭС-БАСКЕТ” төрийн бус байгууллагатай хамтран 2020 оны 10 дугаар сарын 17–20-ны өдрүүдэд “Буянт Ухаа” спортын ордонд зохион байгуулж 84 сургуулийн 96 байгийн 1152 тамирчинд өрсөлдөж шилдгээ тодруулж улс төсвөөс 31.000.000 төгрөг зарцуулсан байна. Мөн I-V үе шатад 121 сургуулийн 86.624 сурагчдыг хамруулсан байна.

Нийслэлийн Засаг даргын нэрэмжит “Улаанбаатар лиг” волейболын тэмцээнийг Монголын волейболын холбоотой хамтран нийслэлийн 9 дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд 2 нас /дунд 14-15 хүртэлх нас, ахлах 15-18 нас/-ны ангиллаар 3 шаттай зохион байгуулахаар төлөвлөсөн бөгөөд 2019 оны есдүгээр сарын 10-аас 2020 оны нэгдүгээр сарын 10-ны хооронд анхан шатны тэмцээнийг явуулж 9 дүүргийн 64 сургуулийн 30.800 сурагчдыг хамруулсан. Нийслэлийн шигшээ тэмцээнийг 2 насны ангиллаар 2020 оны 11 дүгээр сарын 09-10-ны өдрүүдэд “Чингэлтэй дүүргийн биеийн тамир, спортын ордонд зохион байгуулж 44 сургуулийн 832 сурагчид оролцсон.Тус тэмцээний бүх шатанд давхардсан тоогоор 110 сургуулийн 31.630 сурагчдыг оролцуулж улс төсвөөс 16.392.000 төгрөг зарцуулсан байна.

Нийслэлийн Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “Дуулиан-2020” хөл бөмбөгийн тэмцээнийг 3 үе шаттай охид, хөвгүүд тус бүр 4 нас / 11 нас, 13 нас, 15 нас, 17 нас/-ны ангиллаар нийслэлийн 9 дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд 2019 оны есдүгээр сараас 2020 оны нэгдүгээр сарын хооронд анхан шат /I-II үе шат/-ны тэмцээнийг явуулж 87 сургуулийн 30.000 сурагчдыг хамруулсан. Тус тэмцээний III шат буюу нийслэлийн шигшээ тэмцээнийг 2020 оны 12 дугаар сард зохион байгуулахаар төлөвлөсөн боловч Улсын онцгой комиссын 2020 оны 34 дүгээр хурлын тэмдэглэл, Нийслэлийн Засаг даргын 2020 оны “Коронавируст /Ковид-19/ цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай” А/1241, Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай А/1242, Гамшгаас хамгаалах Бүх нийтийн бэлэн байдлын зэргийг бууруулсантай холбогдуулан хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай А/1280 дугаар захирамжуудаар олон нийтийг хамарсан спортын арга хэмжээг зохион байгуулахыг хориглосон тул арга хэмжээг явуулах боломжгүй болсон.

		<p>Аж ахуйн нэгж байгууллагуудын дунд зохион байгуулагддаг “UB CUP” тэмцээнийг II улиралд зохион байгуулахаар төлөвлөгдсөн байсан боловч Дэлхий нийтэд тархаад байгаа “Covid-19” цар тахал буюу коронавирусаас урьдчилан сэргийлэх зорилгоор гаргасан Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн “Шинэ коронавирусийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 30 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны “Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/108 дугаар захирамжийн дагуу хойшлогдсон. Мөн Монгол улсын Засгийн газрын 2020 оны 103 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1114 дүгээр захирамжаар нийтийг хамарсан олон нийтийн арга хэмжээг нээсэн тул тус тэмцээнийг 2020 оны 11 дүгээр сарын 15-25-ны өдрүүдэд зохион байгуулахаар заавар удирдамжаа гарган бэлтгэл ажлаа хангаад байсан боловч Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1241 дугаар захирамжаар нийтийг хамарсан уралдаан тэмцээн зохион байгуулахыг хориглосон тул тэмцээн зохион байгуулагдаагүй.</p>				
	<b>Үр дүн</b>	<p>Багийн спортоор дамжуулан нийслэлийн хүүхэд, багачуудыг хөгжүүлэх зорилгоор “Улаанбаатар лиг” сагсан бөмбөг, волейболын тэмцээн, “Дуулиан-2020” хөлбөмбөгийн тэмцээнийг тогтмол зохион байгуулж жил бүр 6610 багийн 160 мянган гаруй сурагчидыг, “UB cup” хөлбөмбөгийн тэмцээнийг иргэдийн дунд зохион байгуулж 170-350-иад иргэдийг тогтмол хамруулсан байна.</p>				
		<b>Өсвөр үе, хүүхэд, залуучуудын бие бялдрыг чийрэгжүүлэх, авьяас, ур чадварыг хөгжүүлэх үйл ажиллагааг багийн спортоор дамжуулан хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлж, үндэсний болон өвөл, зуны спортын төрлөөр 30-аас доошгүй уралдаан тэмцээн жил бүр зохион байгуулна.</b>	<b>НСХ</b>	<b>Ш.Анхмаа</b>	<b>100%</b>	<b>100%</b>
<b>8</b>	<b>4.4.8</b>	<p>Өсвөр үе, хүүхэд, залуучуудын бие бялдрыг чийрэгжүүлэх, авьяас, ур чадварыг хөгжүүлэх үйл ажиллагааг багийн спортоор дамжуулан хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор:  <b>2017 онд: Спортын уралдаан тэмцээнийг</b> Нийслэлийн хэмжээнд нийт 249 спортын уралдаан, тэмцээнд 4313 байгууллагын 62800 иргэнийг хамруулан улсын төсвөөс 141.061.230 төгрөг, захирамжаар 33.461.300 төгрөг, бусад эх үүсвэрээс 27.615.000 төгрөг нийт 202.137.530 төгрөг зарцуулсан. Нийслэлийн хэмжээнд <b>нийтийн биеийн тамирын</b> 510 арга хэмжээ зохион байгуулж 11.863 байгууллагын 709.961 иргэнийг хамруулан улсын төсвөөс 169.266.600 төгрөг, захирамжаар 237.553.940 төгрөг бусад зардлаас 116.008.800 төгрөг нийт 522.829.340 төгрөгийг зарцуулсан. 2017 онд нийт биеийн тамир, спортын 759 арга хэмжээг зохион байгуулж 772.761 хүнийг хамруулсан байна.  <b>2018 онд:</b> Нийслэлийн хэмжээнд 259 спортын уралдаан тэмцээн зохион байгуулж 4082 байгууллагын 204.224 тамирчныг хамруулан улсын төсвөөс 208.478.220 төгрөг, нийслэл, дүүргийн Засаг даргын нөөц сангаас 157.821.000 төгрөг зарцуулсан. <b>Нийслэлийн хэмжээнд нийтийн биеийн тамирын</b> 561 арга хэмжээ зохион байгуулж 11083 байгууллагын 760.835 иргэнийг хамруулан улсын төсвөөс 192.004.960 төгрөг, нийслэл, дүүргийн Засаг даргын нөөц сангаас 427.838.256 төгрөг зарцуулсан. 2018 онд нийт биеийн тамир, спортын 820 арга хэмжээг зохион байгуулж 965059 хүнийг хамрууллаа.</p>				

		<p><b>2019 онд: Спортын уралдаан тэмцээн</b> Нийслэлийн хэмжээнд спортын 254 уралдаан тэмцээн арга хэмжээ зохион байгуулж 198.566 иргэнийг хамруулж, улсын төсвөөр 186.934.600 төгрөг, захирамжаар 387.965.500 төгрөг, бусад эх үүсвэрээс төсвөөс 47.955.000 төгрөг, нийт 622.855.100 төгрөг зарцуулсан.Нийслэлийн хэмжээнд <b>нийтийн биеийн</b> 443 арга хэмжээ зохион байгуулж 9.935 байгууллагын 756.451 иргэнийг хамруулж, улсын төсвөөр 99.809.956 төгрөг, захирамжаар 514.541.320 төгрөг, бусад төсвөөс 22.199.000 төгрөг, нийт 636.550.276 төгрөг зарцуулсан.2019 онд биеийн тамир, спортын 697 арга хэмжээг зохион байгуулж 955017 хүнийг хамруулж 2.970.514.682 төгрөгийг зарцуулсан байна.</p> <p><b>2020 онд: Спортын уралдаан тэмцээн</b> Нийслэлийн хэмжээнд жилийн эцсийн байдлаар 46 удаагийн уралдаан тэмцээн зохион байгуулж 9876 байгууллагын 153.803 иргэнийг хамруулсан бөгөөд улсын төсвөөс 78.216.300 төгрөг, Зүүн хойд Азийн бизнес, аялал жуулчлал, соёл, санхүүгийн төв болох арга хэмжээний зардлаас 31.000.000 төгрөг, бусад төсвөөс 561.000 төгрөг, нийт 114.826.300 зарцуулсан байна. Биеийн тамирын 172 арга хэмжээ зохион байгуулж 2961 байгууллагын 58.310 иргэнийг хамруулсан бөгөөд улсын төсвөөс 110.660.550 төгрөг, орон нутгийн төсвөөс 76.427.500 төгрөг, бусад төсвөөс 33.830.000 төгрөг, нийт 220.918.050 төгрөг зарцуулсан байна.</p> <p>Төлөвлөгөөт хуваарийн дагуу бусад тэмцээн уралдааныг Дэлхий нийтэд тархаад байгаа “Covid-19” цар тахал буюу коронавирусаас урьдчилан сэргийлэх зорилгоор гаргасан Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн “Шинэ коронавирусийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 30 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны “Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/108 дугаар захирамжийн хүрээнд тодорхойгүй хугацаагаар хойшлуулаад байсан боловч Коронавирусын халдвар дахин дэгдсэнтэй холбоотойгоор Засгийн Газрын 2020 “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 159, “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 178, “Бэлэн байдлын зэргийг бууруулах тухай” 209 дүгээр тогтоолууд, Улсын онцгой комиссын 2020 оны 34 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны “Коронавируст /Ковид-19/ цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай” А/1241, Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай А/1242, Гамшгаас хамгаалах Бүх нийтийн бэлэн байдлын зэргийг бууруулсантай холбогдуулан хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай А/1280 дугаар захирамжуудаар олон нийтийг хамарсан спортын арга хэмжээг зохион байгуулахыг хориглож улс орон даяар бүх нийтийн бэлэн байдлын зэрэг болон хөл хорио тогтоосоны улмаас арга хэмжээг явуулах боломжгүй болсон.</p>				
	Үр дүн	Нийслэлийн хэмжээнд жил бүр нийтийн биеийн тамир, спортын <b>26-42</b> арга хэмжээг зохион байгуулж <b>700-900</b> гаруй мянган иргэдийг тогтмол хамруулж байгаа нь нийслэлийн иргэдийн 52 хувийг хамруулсан байна.				
9	4.4.9	Нийслэлд болон Сүхбаатар, Баянзүрх, Налайх, Баянгол, Чингэлтэй дүүрэгт спортын 6 цогцолбор барих ажлыг үе шаттай хэрэгжүүлж, өвөл, зуны спортын төрлийн биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн цогцолбор барьж байгуулах ажлыг дэмжиж ажиллана.	НСХ	Ш.Анхмаа	75%	70%

		<p>Нийслэлд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа нийслэл болон 5 дүүргийн спорт цогцолборын ажлын гүйцэтгэл 30-95%-тай явж байна. Нийслэлд шинээр баригдаж байгаа спорт цогцолборуудын ажлын биелэлтийг улирал бүр гарган дээд шатны байгууллагуудыг мэдээллээр ханган ажиллаж байна. Үүнд:Дээрх спорт цогцолборуудын барилгын ажилд 2017 оноос өмнөх онуудад улсын төсвөөс 21488,5 сая төгрөгийг зарцуулсан.</p> <p><b>2017 онд:</b> нийслэл болон 5 дүүргийн спорт цогцолборыг барих ажлын гүйцэтгэл 10-70 хувьтай хэрэгжсэн бөгөөд 3353.0 сая төгрөг улсын төсөвт тусгагдан зориулалтын дагуу зарцуулагдсан.</p> <p><b>2018 онд:</b> тус цогцолборуудын барилгын ажлын гүйцэтгэл 20-85 хувьтай хэрэгжиж, улсын төсөвт 5389.4 сая төгрөг тусгагдсаныг зориулалтын дагуу зарцуулсан.</p> <p><b>2019 онд:</b> тус цогцолборуудын барилгын ажлын гүйцэтгэл 30-95 хувьтай хэрэгжиж, улсын төсөвт тусгагдаж 13.438.8 сая сая төгрөг зориулалтын дагуу зарцуулагдсан.</p> <p><b>2020 онд:</b> Нийслэл болон дүүргүүдийн спорт цогцолборуудын 6 барилгын ажлыг хийж гүйцэтгэхэд улсын төсөвт 6.605.600.000 төгрөг тусгагдсан бөгөөд барилгын явц дунджаар 75 хувийн гүйцэтгэлтэй байна. Спорт цогцолбор тус бүрээр тодруулбал:</p> <p>1.Баянгол дүүргийн спорт цогцолборын нийт өртөг 9005,4 сая төгрөг бөгөөд урд жилүүдэд 5002.0 сая төгрөгийн санхүүжилтээр барилгын ажлыг гүйцэтгэсэн. 2020 онд 2.2 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдаж БСШУСЯ-тай гэрээ байгуулан “Молор Констракшн” ХХК нь тус барилгын ажлын 95%-ийг гүйцэтгээд байна.</p> <p>2.Баянзүрх дүүргийн спорт цогцолборын нийт өртөг 8229.3 сая төгрөг бөгөөд нийт 731.5 сая төгрөгийн санхүүжилтийг урд жилүүдэд авч тус барилгын ажлын 90%-ийг гүйцэтгэгч байгууллага болох "Атимос трейд" ХХК хийж гүйцэтгээд байгаа бөгөөд 2020 оны төсөвт санхүүжилт суугдаагүй байна.</p> <p>3.Чингэлтэй дүүргийн спорт цогцолборын нийт өртөг 14164.3 сая төгрөг бөгөөд гүйцэтгэгч байгууллага “Люкс-вүүд” ХХК нь нийт ажлын 98%-ийг хийж гүйцэтгээд байна. А,Б блокийг улсын комисс хүлээн авч гэрчилгээ олгож ашиглалтад оруулсан.С блокийн барилгын ажлыг улсын комисс хүлээж аваагүй байна. 4.Налайх дүүргийн спорт цогцолборын нийт өртөг 10397.9 сая төгрөгөөр “БҮРД констракшн“ ХХК нь нийт ажлын 95%-ийг хийж гүйцэтгээд байна. 2020 оны төсөвт дулааны шугам холбох шаардлагатай нэмэлт санхүүжилт суугдаагүй байна.</p> <p>5.Сүхбаатар дүүргийн спорт цогцолборын нийт өртөг 7377.4 сая төгрөг бөгөөд урд онуудад 2800.0 сая төгрөгөөр барилгын ажлын 30%-ийг хийж гүйцэтгүүлсэн. 2020 оны төсөвт 200 сая төгрөгийн санхүүжилтээр “Грейн ресурс” ХХК нь барилгын ажлын 40%-ийн хийж гүйцэтгэсэн байна.</p> <p>6. Нийслэлийн спорт цогцолборын нийт өртөг 7280.2 сая төгрөг бөгөөд урд онуудад 3257.0 сая төгрөгөөр барилгын ажлыг гүйцэтгэгч байгууллага "Үүрэг трейд" ХХК нь 30%-ийг хийж гүйцэтгээд байна. 2020 онд 4023.2 сая төгрөгийг шийдвэрлүүлэх шаардлагатай байсан боловч улсын төсөвт санхүүжилт суугдаагүй байна.</p>				
<b>Үр дүн</b>		Нийслэл болон 5 дүүрэгт баригдаж байгаа спортын цогцолборын барилгын ажил 2017 онд дунджаар 45%, 2018 онд дунджаар 61%, 2019 онд дунджаар 70.8%, 2020 онд дунджаар 75% -ийн гүйцэтгэлтэй байна.				
<b>10</b>	<b>4.4.10</b>	<p><b>Төв усан бассейнд их засвар хийж, нийслэлийн иргэдийг усан спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлнэ.</b></p> <p>Хувьчлагдсан тул үнэлэх боломжгүй.</p>	<b>НСХ</b>	<b>Ш.Анхмаа</b>	<b>Үнэлэх боломжгүй</b>	<b>Үнэлэх боломжгүй</b>



<b>Хэрэгжилт:</b>	<b>94.7%</b>	<b>100%</b>
-------------------	--------------	-------------

ХЯНАСАН:

НИЙСЛЭЛИЙН СПОРТЫН ХОРООНЫ  
ДАРГА Ж.ГАНБОЛД

ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

СПОРТЫН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ  
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Б.ОЮУНТУЯА

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

ГАДААД ХАРИЛЦАА, СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ, ТАЙЛАН МЭДЭЭ  
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Н.ӨЛЗИЙЖАРГАЛ